Эрдэс баялгийн салбар дахь гэрээг ил тод болгох асуудлын хүрээнд байгуулагдсан Ажлын IV хэсгийн хурлын тэмдэглэл №1 /2015-03-24/

Ажлын IV хэсгийн хурал 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 15:00 цагт Уул уурхайн яамны хурлын танхимд зохиогдов. Хуралд хэсгийн ахлагч Уул уурхайн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нэргүй, гишүүн Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Орлогын хэлтсийн мэргэжилтэн Ц.Гэрэлчимэг, Петро матад ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амарзул, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, нарийн бичиг ОҮИТБС-ын ажлын албаны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар оролцов.

Хэсгийн гишүүн Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан хөдөө томилолтоор явж буй, Газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Ч.Амгалан албан ажил давхардсаны улмаас хуралд оролцсонгүй. Уул уурхайн яамны Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн Т.Зууннаст хуралд урилгаар оролцов.

Хурлын эхэнд нарийн бичиг Б.Дэлгэрмаа гишүүдэд ажлын удирдамж, хүлээж буй үр дүнгийн талаар товч танилцуулав. Хурлыг Уул уурхайн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нэргүй удирдан явууллаа.

Б.Нэргүй: Сайн байцгаана уу? Тэгэхээр эхлээд бид ямар хүрээнд ажиллахаа тодорхойлох шаардлагатай байна. Бүтээгдэхүүн хуваах 17 гэрээ байна. Тогтвортой байдлын гэрээ хэд байгаа вэ? Сангийн яам мэдээлэл хийх үү?

Ц.Гэрэлчимэг: Чинхуа МАК болон Цайрт минералтай байгуулсан Тогтвортой байдлын 2 гэрээ байгаа. Хугацаа нь дуусч байгаа.

Б.Нэргүй: За өөр? Концессын гэрээ хамаарах уу?

Б.Дэлгэрмаа: Гэрээний ил тод байдал сэдвээр 12 сард зохион байгуулсан олон талт оролцогчдын хэлэлцүүлгийн үеэр ч, өмнө нь ч компаниудын зүгээс буюу Уул уурхайн ассоциац Засгийн газартай байгуулж байгаа гэрээг ил тод болгох талаар байр сууриа илэрхийлсэн. Тэгэхээр концессийн гэрээ нь орох болов уу.

Б.Нэргүй: Төрийн өмчийн хорооноос энэ ажлын хэсэгт төлөөлөл бий юу?

Б.Дэлгэрмаа: Байхгүй. Гэхдээ шаардлагатай гэвэл урьж оролцуулах боломжтой байх.

Б.Нэргүй: Төрийн өмчийн хорооноос гайгүй ажил хийгээд байхаар хүн байвал болж байна, хуралдаа ирэхгүй, оролцохгүй байвал бас хэцүү. Тэгэхээр үүнийг сайн бодолцоорой.

Б.Дэлгэрмаа: Орон нутгийн засаг захиргаатай гэрээ байгуулж байгаа.

Д.Эрдэнэчимэг: 12 сард болсон хэлэлцүүлэгт орон нутгийн удирдлагуудын төлөөлөл оролцсон. Тэд хэлэхдээ орон нутагтай байгуулж байгаа гэрээг нууцлах шаардлага байхгүй, ил тод байгаа гэж байсан. Гэхдээ нийтэд бодитоор бүгд ил тод болсон зүйл байхгүй байна.

Б.Нэргүй: Загвар гэрээ Засгийн газрын хурлаар батлагдвал энэ асуудал цэгцрэх байх. Одоо бол өөр өөр, харилцан адилгүй яваад байгаа.

Б.Дэлгэрмаа: Орон нутагтай ус ашиглах гэрээ байгуулдаг юм байна лээ. Манай ОҮИТБС-ын аудитын нэгтгэл тайланд орон нутагтай байгуулсан гэрээнүүдийн судалгааг авж, нэгтгэж гаргадаг. Ямар гэрээг, хэнтэй байгуулсан, гэрээг дүгнэсэн эсэх гэсэн дүгнэлт хүснэгт гардаг. Гэрээний хуулбарууд аудиторт байгаа, авч болно гэж байсан.

Б.Нэргүй: За орон нутагтай байгуулсан гэрээг оруулая. Энэ их олон гэрээ байгаа байх.

Д.Эрдэнэчимэг: Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлийн дагуу байгуулж буй гэрээ, ус ашиглах гэрээ, газар ашиглах гэрээ гээд орон нутагтай үндсэн энэ 3 гэрээг байгуулдаг юм байна лээ.

Б.Нэргүй: Компанийн нууцын тухай хуульд нууц гэж тодорхойлсон мэдээллийг бид ил тод болгохгүй, тийм шаардлага ч байхгүй. Өөр хамрах хүрээ юу байна?

Д.Эрдэнэчимэг: Урт нэртэй хуулийг дагаж мөрдөх журамд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор загвар гэрээ боловсруулах ажлын хэсэг гарсан гэсэн. Энэ гэрээ бас орох ёстой болов уу?

Б.Нэргүй: Урт нэртийн гэрээ гэж байгаа. За үүнийг хамруулая.

Д.Эрдэнэчимэг: Ашигт малтмалын газартай компаниуд уулын ажлын биелэлтийг тайлагнах гэрээ гэж байгуулдаг болсон гэсэн. Энэ жилээс шинээр байгуулж байгаа гэж ойлгосон. Энэ бас орох уу?

Б.Дэлгэрмаа: Энэ гэрээний утга, ямар заалтууд орж байгаа, тэдгээрийг нийтэд ил тод болгох зайлшгүй шаардлага, ач холбогдлыг судалсан зүйл байгаа юу?

Д.Эрдэнэчимэг: Байхгүй байгаа. Гэхдээ бид нэгэнт хамрах хүрээг ярьж байгаа тул энэ ажлын хэсгээр авч үзээд судлах нь зүйтэй болов уу.

Б.Нэргүй: Энэ ч ач холбогдол багатай байх. Гол нь хугацаандаа тайлагнах заалтууд орсон байгаа. Харин бид гэрээ байгуулсан хэдэн компани байсан, түүнээс хэд нь тайлангаа ирүүлээгүй гэх мэтээр дүгнэлт мэдээг ил тод болгож болно. Эсхүл энэ гэрээг хамрах хүрээндээ оруулаад судалж байгаад ил тод болгох эсэх дээр дүгнэлт гаргаж болно.

Б.Дэлгэрмаа: Ер нь ямар гэрээг ил тод болгох вэ гэдэг дээр талууд нэгдсэн ойлголтонд бүрэн хүрээгүй байгаа. Жишээ нь компаниудын зүгээс зөвхөн Засгийн газартай байгуулсан гэрээг ил тод болгох боломжтой гэхээр, иргэний нийгмийн зүгээс илүү өргөн хүрээг шаарддаг.

Тэгэхээр энэ ажлын хэсэг илүү том зургаар буюу эрдэс баялгийн салбарт ийм төрлийн гэрээнүүд байгуулагдаж байна, утга агуулга нь ийм байна, тэдгээрээс энийг нь ил тод болгох нь ач холбогдолтой байна, тэрийг нь ил тод болгох шаардлага байхгүй, ач холбогдол багатай, эсхүл хууль эрх зүйн орчин бүрдээгүй ч юмуу гэх мэт байдлаар яг тодорхой жагсаалт гаргаад, тайлбар, дүгнэлт гаргаад явах нь зөв байх.

Д.Эрдэнэчимэг: Ашигт малтмалын газартай геологийн ажлын гэрээ, ашиглалтын өмнөх гэрээ байгуулдаг, эдгээрийг нууцлах шаардлага байхгүй гэж Ашигт малтмалын газрын төлөөлөл хэлэлцүүлгийн үеэр дурьдаж байсан. Ер нь Ашигт малтмалын газар дээр ямар гэрээнүүд байна, тэдгээрийг тодруулж ярилцах хэрэгтэй юм шиг байна.

Б.Нэргүй: Зэ тэгвэл багцлаад Ашигт малтмалын газартай байгуулж буй гэрээ гээд оруулая. Газрын тос дээр бүтээгдэхүүн хуваах гэрээнээс өөр ямар гэрээ байгаа вэ? Нефть бүтээгдэхүүний гэрээ гэж байх уу?

Д.Амарзул: Худалдааны гурвалсан гэрээ гэж байдаг юм бол уу? Петрочайна л мэдэх байх даа.

Б.Нэргүй: Нефть импортлогч нартай бүтээгдэхүүн импортлох гэрээ гэж байгаа л байх даа. Үүнийг Газрын тосны газрын Амгалан хариулах байх. Амгалан хуралд яагаад ирээгүй вэ?

Б.Дэлгэрмаа: Ажил нь 5шард байдаг. Нэгдүгээрт ажил давхардсан, хоёрдугаар хол гэж байсан. Имэйлээр саналаа өгнө гэсэн.

Б.Нэргүй: Дэлгэрмаа тэгвэл Амгалантай холбогдож тодруулах уу? Импортлогчидтой байгуулж буй гэрээ бий эсэх, тэдгээрийг ил тод болгох шаардлага байгаа эсэх талаар.

Б.Дэлгэрмаа: Ер нь энэ нефть импортолж буй компаниуд олборлох салбартай шууд хамааралтай юмуу? Тэд чинь шатахуун импортлоод, нийтийн хэрэгцээнд борлуулаад явж байгаа биздээ. ОҮИТБС-ын тайлан ч гаргадаггүй юм байна.

Т.Зуннаст: Хамаарахгүй.

Б.Нэргүй: За тэгвэл тайлан гаргадаг гэдгээр нь хүрээг тогтооё. Ингээд 6 гэрээ боллоо. Энэ хүрээндээ ажиллъя. Зууннастыг энэ ажлын хэсэгт оруулая. Ер нь цаашид Зууннастад ажлын 5 хэсгийн явцын мэдээллийг тогтмол өгч байх хэрэгтэй. Хууль дээр ажиллах учраас эдгээр ажлын хэсгүүдэд яригдсан асуудлуудыг харгалзахын тулд яамны хэн нэгэн хүн заавал мэдээлэл авч байх нь зүйтэй, тэр нь Зууннаст байна. Ашигт малтмалын газраас төлөөлөл оруулах уу?

Т.Зууннаст: Оруулах нь зүйтэй. ОҮИТБС-ын мэргэжилтэнг нь оруулах уу?

Д.Амарзул: Газрын тосны газартай бүтээгдэхүүн хуваах гэрээг газрын тосны хайгуулын үйл ажиллагаанаас гадна занар дээр тусад нь байгуулдаг болсон байгаа.

Б.Нэргүй: Тийм занарын гэрээ гэж байгаа. Үүнийг оруулъя. Ингээд 7 төрлийн гэрээ боллоо. За ингээд гэрээнүүдээ татаж авъя, сантай болъё. Бичгийг ажлын албанаас явуулъя. Тэгээд эхнээс нь бүгдээрээ гэрээнүүдтэй ажиллаад явъя. Гэрээ байгуулагч талуудтай уулзалт зохион байгуулъя. Гэрээг ил тод болгоход ямар хүндрэл байгаа талаар ярилцъя. Тэгээд төслийн тодорхойлолт гаргая. Тухайлбал, ийм үр өгөөжтэй төсөл юм байна, ийм гэрээ байгуулсан юм байна, гэрээг ил тод болгосноор нийтэд ийм үр өгөөж бий болох юм байна, ийм заалтууд нь хаалттай байх ёстой юм байна гэх зэрэг байдлаар дүгнэлт, зөвлөмж гаргая. Ингээд ажиллаад явах уу? Зөвлөмжөө тэгээд хэнд гаргах юм бэ?

Б.Дэлгэрмаа: Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулна.

Б.Нэргүй: Ингэж 5 ажлын хэсэг байгуулах шийдвэрийг хэн, яагаад гаргасан юм?

Б.Дэлгэрмаа: Үндэсний зөвлөлийн хуралдааны үеэр гишүүд асуудал дэвшүүлсэн, тэдгээр асуудлуудыг шийдвэрлэх үүднээс урьдаар цомхон баг гаргаж ажиллуулах шийдвэрийг Үндэсний зөвлөл буюу Ерөнхий сайдын ахлах зөвлөх гаргасан байгаа.

Б.Нэргүй: За бид сая шийдвэрээ гаргаад яваад байгаа шүү. Дэлгэрмаа сайн тэмдэглэж аваарай.

Б.Дэлгэрмаа: Талуудтай уулзах уулзалтуудыг яаж зохион байгуулах юм бэ? Гэрээний төрлөөр нь хуваагаад, өөр өөр өдөрт хуваарилах уу? Орон нутагтай гэрээ байгуулсан компаниудыг яах вэ? Олон компани байгаа шүү дээ.

Б.Нэргүй: Бүтээгдэхүүн хуваах гэрээтэйг нэг, тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын гэрээтэйг нэг өдөр товлочих, бүгдтэй нь л уулзах нь зөв. Орон нутагтай харин хэдэн гэрээ байгуулсныг мэдэх арга байна уу?

Б.Дэлгэрмаа: Дэд зөвлөлүүд рүү холбоо барьж, албан тоот явуулж судалгаа авч болно.

Б.Нэргүй: За тэгвэл шийдвэр дээрээ дэд зөвлөлүүдээс орон нутагтай байгуулсан гэрээний судалгаа авах гээд оруулаарай.

Д.Амарзул: Орон нутагтай ямар гэрээ, хэдэн гэрээ байгуулсан байна гэдгийг л судална биз дээ. Түүнээс хэнтэй байгуулж байгааг заавал судлах шаардлага байхгүй байх.

Б.Нэргүй: Эхлээд хэдүүлээ гэрээнүүдийг татаж аваад, судалъя. Жишээлбэл, Төв аймаг хэнтэй, ямар гэрээ байгуулж байна? Өмнөговь аймаг ямар гэрээ байгуулж байна? давуу, сул тал зэргийг дүгнэж үзье.

Д.Эрдэнэчимэг: Нээлттэй нийгэм форум 12 сард талуудтай хамтран гэрээний ил тод байдал сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж гаргасан. Тэр зөвлөмжөөс тодорхой ажлуудыг 2015 онд хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөөнд тусгасан байгаа. Тухайлбал, ил тод болсон гэрээнүүдийн нэгдсэн мэдээллийн онлайн сан байгуулах, магадгүй энэ санг ОҮИТБС-ын ажлын албаны цахим хуудастай холбох нь зүйтэй байх, мөн дээр нь эрх зүйн орчинг судлах,

гэрээг ил тод болгосон гадаад орнуудын туршлага судлах зэрэг ажлуудад тодорхой зардал мөнгө төсөвлөсөн байгаа. Тиймээс эдгээр ажлыг энэ ажлын хэсгийн төлөвлөгөөтэй уялдуулах, хамтатгах боломжтой.

Т.Зуннаст: Бусад оронд гэрээний ил тод байдал гэдгийг юу гэж авч үздэг юм, тэдний туршлагыг судлах нь чухал байна. Мөн зөвлөмждөө оруулах хэрэгтэй.

Б.Нэргүй: За Эрдэнэчимэг 3 санал хэллээ. Мэдээллийн сан байгуулах, чухам энэ сан нь ямар хэлбэр, агуулгатай байх зэргийг форумтай тохирох хэрэгтэй. Мөн бусад орны туршлага судлахдаа болж өгвөл тухайн оронд нь очиж, танилцвал сайн байна. Гуравдугаарт эрх зүйн орчныг судлах гээд энэ гурван ажлыг Нээлттэй нийгэм форумтай хамтран хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөөндөө оруулаарай.

Д.Эрдэнэчимэг: Туршлага судлах аялалын тухайд одоо шууд тодорхой хариу өгөх боломжгүй байна. Судлаад эргээд хариу өгье. Сан байгуулах, эрх зүйн орчны судалгаа хийх зардлыг манайх хариуцах боломжтой.

Д.Амарзул: Судалгаа хийх ажлыг дэмжиж байна. Тэгэхгүй бол өмнөх 12 сарын хэлэлцүүлэг дээр гэрээний ил тод байдал гэдгийг явсаар байгаад бүр худалдан авах гэрээг хүртэл хамруулж ойлгоод, компаний дотоод асуудал руу ороод байх шиг ажиглагдсан.

Б.Нэргүй: Гэрээ ил тод байх асуудлыг нийгэмд их зөв зүйтэй ойлгуулах хэрэгтэй. Талуудын байр суурийг нухацтай авч үзэж, анализ дүгнэлт хийж, үр нөлөөг судалж, хуулийн хүрээнд чамбай ажиллах шаардлагатай. Ажлын төлөвлөгөө гаргая. Түрүүнд яригдсан ажлуудыг хариуцах эзэнтэй, хугацаатай болгоод гишүүдэд санал авахаар хүргүүлье. Та бүгд саналаа өгөөрэй. Ажлын төлөвлөгөөгөө эцэслэж батлаад, явцыг Дэлгэрмаа ахлах зөвлөхөд тогтмол танилцуулаад явъя.

Б.Дэлгэрмаа: Иргэний нийгмийг төлөөлж энэ ажлын хэсэгт орсон Нээлттэй нийгэм форум, ТАН эвсэлд хүсэлт тавьхад гэрээ хаалттай байснаар тухайн иргэдийн ямар эрх, ашиг хөндөгдөж байгаа, чухам ямар нөлөө үзүүлээд байгаа талаар иргэдээс авсан кейс судалгаа буюу асуумж байгаа юу? байхгүй бол тэдгээрийг хамтарч хийх саналтай байна. Энэ ажлыг бас ажлын төлөвлөгөөндөө оруулах уу?

Б.Нэргүй: Тэгье. 1-2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар оруулъя. За өөр санал байна уу? Байхгүй бол хурлаа өндөрлөе.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээ (газрын тос, занар), тогтвортой байдлын гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ, концессын гэрээ, орон нутгийн засаг захиргаатай байгуулж буй гэрээ, Ашигт малтмалын газартай байгуулж буй гэрээ гэсэн үндсэн 7 төрлийн гэрээний хүрээнд ил тод байдлыг авч үзэхээр тогтов.

2. Гэрээ байгуулсан талуудад албан тоот илгээж, гэрээний хуулбарыг татан авах, ОҮИТБС-ын дэд зөвлөлүүдээс орон нутагтай байгуулсан гэрээний судалгаа авахыг ОҮИТБС-ын ажлын албанд даалгав.

3. Гишүүдийн гаргасан саналыг тусган ажлын төлөвлөгөө боловсруулж, 4 сарын 3-ны дотор гишүүдэд хүргүүлж, санал авахыг нарийн бичиг /Б.Дэлгэрмаа/-т даалгав.

4. Ажлын хэсэгт Уул уурхайн яамны СБТГ-ын Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн Т.Зууннаст, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Г.Оюунтуяаг нэмж оролуулахаар шийдвэрлэв.

Хурал 15 цаг 40 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Уул уурхайн яамны Стратеги бодлого,
төлөвлөлтийн газрын даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч Б.Нэргүй

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОҮИТБС-ын ажлын албаны
мэргэжилтэн Б.Дэлгэрмаа